



**БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН  
ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН  
ДАРГЫН ТУШААЛ**

2023 оны 06 сарын 21 өдөр

Дугаар А/20

Улаанбаатар хот

**Зөвлөмжийн төлөвлөгөө  
батлах тухай**

Монгол Улсын Эрүүл Мэндийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.1 дэх заалт, Нийслэлийн Эрүүл мэндийн газрын даргын 2023 оны А/02 дугаар “харъяа эрүүл мэндийн байгууллагуудад үр дүнгийн урамшуулал олгох” тушаалыг ханган ТУШААХ нь:

1. Байгууллагын үйл ажиллагааны хэрэгжилт хяналт-шинжилгээ, үнэлгээний дүгнэлтээс гаргасан зөвлөмжийн хэрэгжилтийг ханган хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг хавсралтаар баталсугай.
2. Зөвлөмжийн хэрэгжилтийн төлөвлөгөөний хэрэгжилтийг ханган ажиллахыг чанартай ажил зохион байгуулахыг бүх ажилчдад үүрэг болгосугай.
3. Зөвлөмжийн хэрэгжилтийн төлөвлөгөөний биелэлтийг хагас бүтэн жилээр тайлагнаж ажиллахыг Хүний нөөцийн ажилтан /Г.Гантуяа/-д даалгасугай

ДАРГА



Х.ГАНБАТ

Багахангай Эрүүл мэндийн төвийн даргын  
2023 оны 06 дугаар сарын 21-ны өдрийн  
тушаалын хавсралт



2022 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГАА ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНЭЭС  
ДҮГНЭЛТИЙН ЗӨВЛӨМЖ

№	Үйл ажиллагаа	Хугацаа	Хариуцсан ажилтан	Хүрэх түвшин
Өгсөн үүрэг 1: Байгууллагын 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд үйл ажиллагааны бичмэл тайланг хавсаргаж ирүүлээгүй, гүйцэтгэлийн төлөвлөгөөний арга хэмжээ нь зорилтот түвшинтэй уялдаагүй, шалгуур үзүүлэлт нь тодорхой бус				
1	Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний тайлан биелэлтийг гаргахдаа товч бөгөөд тодорхой оновчтой шалгуур үзүүлэлтийг хангасан эсэхийг бичиж байгууллагын удирдлагаар хянуулж тайлагнаж байх.	Жилдээ	Тайлан гаргаж байгаа бүх ажилчид	Тайланг хугацаанд нь чанартай хүргэж ажилласан байна.
2	Байгууллагын үйл ажиллагааны бичмэл тайланг төлөвлөгөөний биелэлтэнд хавсаргаж явуулж хэвшүүлэх	Тухай бүр	Хүний нөөц, дотоод хяналтын ажилтан	Хагас бүтэн жилд тайлагнасан байна.
Өгсөн үүрэг 2: Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн хэрэгжилтийн баталгаажуулалт, тайлан хангалтгүй				
3	Сургалт хөгжлийн хөтөлбөрийг боловсруулж батлуулах, хэрэгжилтийг ханган ажиллах	Жилдээ	Хүний нөөц, дотоод хяналтын ажилтан	Хөтөлбөр төлөвлөгөөтэй ажилласан байна.
4	Нийгмийн батлгааг хангах хөтөлбөрийг шинэчлэн боловсруулж батлуулж, хэрэгжилтийг ханган ажиллах.	Жилдээ	Хүний нөөц, дотоод хяналтын ажилтан	Хөтөлбөр төлөвлөгөөтэй ажилласан байна.
5	Тайланг биелэлтийг чанартай цаг хугацаанд нь холбогдох байгууллагад хүргүүлэн ажиллах.	Тухай бүр	Хүний нөөц, дотоод хяналтын ажилтан	Хагас бүтэн жилд тайлагнасан байна.
Өгсөн үүрэг 3: Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанарын үзүүлэлтийн хэрэгжилтийн тайланг хугацаанд нь ирүүлээгүй				
6	Эмнэлгийн тусламж үйлчилгээний чанарын үзүүлэлтийг улирал бүр гаргаж дүгнэлт хийж ажиллах	Улирал бүр	Статистикч	Чанарын үзүүлэлт сайжирна.
Өгсөн үүрэг 4: мэдээллийн ил тод байдал, тушаал шийдвэр оруулаагүй, дутуу болон				

зарим байгууллагын албан ёсны сайт нь ажиллаагүй				
7	Байгууллагын үйл ажиллагааг иргэдэд сурталчилах ажлыг эрчимжүүлж веб сайт болон цахим хуудсын мэдээллийг баяжилтыг бүрэн хийх	Тухай бүр	Хүний нөөц, дотоод хяналтын ажилтан	Мэдээллийг цаг тухай бүр оруулсан байна.
8	Шилэн дансны мэдээллийг тухай бүр оруулах.	Тухай бүр	Нягтлан бодогч	Мэдээллийг цаг тухай бүр оруулсан байна.
Өгсөн үүрэг 5: хэрэглэгчийн үнэлгээний судалгааг дутуу өгч хангалтгүй ажилласан				
9	Үйлчлүүлэгч болон ажилчдын сэтгэл ханамжийн судалгааг тогтмол авч үнэлэлт дүгнэлт өгч ажиллах	Тухай бүр	Хүний нөөц, дотоод хяналтын ажилтан Чанарын менежер	Үйл ажиллагааг тогтмолжуулсан байна.
10	Тайлан мэдээг цаг хугацаанд нь гаргаж тайлагнаж ажиллах.	Тухай бүр	Хүний нөөц, дотоод хяналтын ажилтан Чанарын менежер	Тайланг цаг хугацаанд нь гаргасан байна.
Өгсөн үүрэг 6 Албан хэрэг хөтлөлт стандартын бус үг үсгийн алдаатай				
11	Албан хэрэг хөтлөлтийн сургалтыг зохион байгуулах, үр дүнг тооцож ажиллах.	Тухай бүр	Архив, бичиг хэргийн ажилтан	Чанар сайжирсан байна.